



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 417

Мөрөн сум

Хамтарсан комиссын бүрэлдэхүүнийг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, “Хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комисс”-ын тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 2000 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн албан бичгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Хөвсгөл аймгийн хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилээр хулгайлагдсан болон бэлчээрээр хил давж алдагдсан малын асуудлыг шийдвэрлэх комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, комиссын ажиллах журмыг хоёрдугаар, хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комиссын ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Комисснын бүрэлдэхүүн хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малын эрлийг нутаг дэвсгэр дээрээ зохион байгуулж, шийдвэрлэхийг комиссын дарга, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан уул, Баянзүрх, Улаан уул, Цагааннуур, Ханх, Цагаан-Үүр, Рэнчинлхүмбэ, Эрдэнэбулган сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Оросын Холбооны Улсын Бүгд найрамдах Тыва, Буриад Улсын комиссуудтай хамтын ажиллагааг сайжруулах, мэдээ мэдээлэл, харилцан туршлага солилцож, идэвх санаачилгатай ажиллахыг (Хөвсгөлийн хэсгийн Хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн туслагч) нарт даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Хөвсгөл аймгийн засаг даргын
2024 оны 01 сарын 16 өдрийн
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

Монгол Улс – Оросын Холбооны Улсын хилээр хулгайлагдсан болон бэлчээрээр хил давж алдагдсан малын асуудлыг шийдвэрлэх комиссын бүрэлдэхүүн

Хулгайлагдсан болон бэлчээрээр хил давж алдагдсан малын асуудлыг шийдвэрлэх комиссын бүрэлдэхүүн:

Комиссийн дарга: - Хөвсгөлийн хэсгийн хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн туслагч

Гишүүд: - Хилийн цэргийн салбарын захирагч

- Хилийн сумын засаг даргын орлогч

- Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, ажилтан, хэрэг бүртгэгч

- Тагнуулын ажилтан

- Хилийн сумын багуудын засаг дарга

- Мал эмнэлэг, үргжийн тасгийн дарга, ажилтан

- Орчуулагч

- Шинжээч (Малын эзэн, малын эмч)

оо

Хөвсгөл аймгийн засаг даргын
2024 оны 01 сарын 16 өдрийн 11:11
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Комиссын ажиллах журам

РЮА0007 9070354

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлиг, Монгол Улс, Олон Улсын Гэрээ, Хэлэлцээр, Хилийн Тухай Хууль, Хилийн асуудлаар гаргасан холбогдох тушаал, захирамжийг хүндэтгэн сахиж, хэрэгжүүлэн дараах журмаар ажиллана.

1. Нэг талын нутаг дэвсгэрээс мал хулгайлагдан хил давж нөгөө Талын нутаг дэвсгэрт орсон тохиолдолд хамтарсан шалгалт явуулж, алдагдсан малыг нөгөө талын нутаг дэвсгэрт хамтран эрэн сурвалжилна.

2. Нөгөө талын нутаг дэвсгэрт алдагдсан малыг эрэн сурвалжлах бусийн гүн нь Талуудын хил орчмын нутаг дэвсгэрээр хязгаарлагдана.

3. Талуудын комиссын бүрэлдэхүүн хүчин төгөлдөр үнэмлэхээр хоёр улсын хилийг мөр хүлээлцэн чиглэлээр буюу алдагдсан мал байж болох чиглэлээр нэвтэрч болно. Зөвхөн хилийн болон цагдаагийн ажилтнууд биедээ хувийн зэвсэг авч явж болно.

4. Комисс нь хилийн асуудлаар мөрдөгдөж байгаа гэрээ, хэлэлцээр тухайн улсын хууль тогтоомжийг хүндэтгэн биелүүлнэ.

5. Тухайн нутаг дэвсгэрийн комисс нь нөгөө талынхаа комиссын бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангана.

6. Малаа хил давуулж алдсан тал мал хил давсан ул мөр, чиглэлийг тогтоож, акт үйлдэж, нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

7. Мэдээлэл хүлээн авсан тал зөрчил болсон хэсэгт 1 хоногоос дээшгүй хугацаанд хүрэлцэн ирж, нөгөө талтай зөрчлийг хамтран шалгаж, мөрийг хүлээж авна.

8. Талууд хамтарсан шалгалтын мөрөөр хулгайлагдсан хил давсан болон бэлчээрээр хил давсан малын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гаргана Шийдвэрт доорх зүйл тусгагдана.

Үүнд:

- Эрэлд оролцох бүрэлдэхүүн, уналга, тээврийн хэрэгсэл, тэдгээрийг улсын хилээр хэзээ, хаагуур, хэрхэн нэвтрүүлэх;
- Эрлийн ажиллагаанд нөгөө талын комиссоос ямар хүмүүсийг оролцуулах;
- Эрэл явуулах чиглэл, маршрут;
- Эрэл явуулах журам;
- Эрлийг явуулах хугацаа, хилээр буцаж нэвтрэх журам болон бусад шаардлагатай асуудлуудыг тусгасан байна.

9. Нөгөө талын нутаг дэвсгэрт ажилласан комиссын ажиллагаа үр дүнд хүрээгүй тохиолдолд анхны цагийн байдал, нэмэгдэл нөхцөл байдлуудыг нөгөө талдаа хүлээлгэн өгнө.

10. Хүлээн авсан талын комисс хулгайлагдсан мал болон хулгайлсан эздийг эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн талд үргэлжлүүлнэ. Ажлын явц үр дүнгээ 7 хоног тутамд нөгөө талдаа мэдэгдэж байна.

11. Эрлийн төгсгөлд комисс нь үр дүнгээ тухай бүр нь Хилийн төлөөлөгчдөө

Хилийн төлөөлөгч нар дээд шатандаа сар бүр бичгээр илтгэж байна.

12. Комиссын бүрэлдэхүүний амь нас аюулгүй байдалд занал хийх, эрлийн ажиллагаанд саад бэрхшээл учруулбал нөгөө талын нутагт ажиллаж буй комисс бие даан эрлийн ажиллагааг зогсоох эрхтэй бөгөөд болсон асуудлын талаар Хилийн бүрэн эрхт төлөөлөгчдөө нэн даруй мэдэгдэнэ.

13.Хоёр тал хил давсан мал, амьтны ул мөр шинж тэмдгийг хүлээн авах, мал амьтныг хүлээлцэх баримт бичгийг Монгол, Орос хэлээр үйлдэнэ.

○○○

Хөвсгөл аймгийн засаг даргын
2024. оны 01. сарын 16. өдрийн 09:00
дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн
сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комиссын ажиллах журам

1. Нутаг дэвсгэрээс нь мал хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан Талын хэсгийн удирдагч нь Хилийн Бүрэн эрхт төлөөлөгчдөөрөө дамжуулан Оросын Холбооны Улсын Бүгд найрамдах Тува, Буриад Улсын хэсгийн удирдагчид мал хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан зөрчлийн тухай мэдээлнэ. Мэдээлэл нь хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малын тоо, төрөл, нас, хүйс, им, тамга, зүс болон алдагдсан хугацаа. газар зэрэг эрэл явуулах шаардагдах өгөгдөхүүнийг агуулна.

2. Нутаг дэвсгэр нь мал хулгайлагдсан болон бэлчээрээр орж ирсэн талын хамтарсан комиссын хэсгийн удирдагч мэдээлэл хүлээн аваад малын нэг талын эрэл үр дүнд хүрээгүй тохиолдолд малын хамтарсан эрлийг зохион байгуулахын тулд хамтарсан комиссын гишүүнийн уулзалтыг хийнэ.

3. Хамтарсан комисс нь малын эрлийг зохион байгуулахад шаардлагатай мэдээллийг судалж. хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх цаашдын ажиллагааны журмын тухай шийдвэр гаргана.

Хамтарсан комиссын шийдвэрт дараах асуудлууд тусгагдана.:

- Эрлийн маршрут, чиглэл;
- Малын эрэл явуулах болон тогтоон барих журам;
- Хамтарсан комиссоос эрэлд оролцох бүрэлдэхүүн, эрэлд оролцох хөсөг, тээврийн хэрэгслүүд, түүнчлэн комиссын гишүүнийг улсын хилээр нэвтрүүлэх газар, хугацаа, журам;
- Олдсон малыг тогтоон барих болон мал эмнэлгийн үзлэг хийх журам, түүнчлэн шаардлагатай үед нутаг дэвсгэрийг хилийн чандаас нэвтэрч болзошгүй мал, амьтны халдварт өвчинөөс сэргийлэх болон тахлын эсрэг арга хэмжээнүүдийг шуурхай хэрэгжүүлэх журам;
- Шаардлагатай бусад асуудлууд.

4. Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг илрүүлсэн тохиолдолд малын эрлийг өөрийн нутаг дэвсгэрт явуулсан хамтарсан комиссын хэсэг нь уг малыг илрүүлсэн, өвчтэй мал, амьтдыг хорио цээрийн зайлшгүй шаардлагаар тогтоон барьж байх явцад урьдчилан сэргийлэх болон малын тахлын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлснийг нотолсон баримт бичиг үйлдэнэ.

5. Малыг улсын хилээр нэвтрүүлэн хүлээлгэн өгөх ажлыг Хилийн Бүрэн эрхт төлөөлөгчдөөс даалгасны дагуу Талуудын Хилийн Бүрэн эрхт төлөөлөгчдийн тохиролцон тогтоосон загварын баримт бичгийн дагуу хилийн болон мал эмнэлгийн албадын төлөөлөгчид гүйцэтгэнэ.

6. Эрэл нааштай үр дүнд хүрээгүй тохиолдолд хамтарсан комисс нь эрэл эхэлснээс хойш 48 цагийн дараа түүнийг зогсоох буюу цаашид үргэлжлүүлэх шийдвэр гаргана.

7.Хамтарсан комиссын гишүүд 1994 оны 8 дугаар сарын 10- ны өдрийн “Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн Газар, ОХУ-ын Засгийн Газар хоорондын Хэлэлцээр”-ийн 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын “в”, “д” хэсэг, 13 дугаар зүйлийн 1, 2 дугаар заалтын дагуу хилээр нэвтэрнэ.

oOo